

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ

Гар бичмэлийн эрхтэй ©

ДЭМБЭРЭЛИЙН НАНДИН-ЭРДЭНЭ

**ӨРХИЙН ЭМЧ, СУВИЛАГЧДЫН АЖЛЫН БАЙРАН ДАХЬ НИЙГЭМ-
СЭТГЭЛ ЗҮЙН ХҮЧИН ЗҮЙЛ БОЛОН ХАЛШРАХ ШИНЖ**

Е- 720102 Нийгмийн эрүүл мэндийн бодлого удирдлага

Нийгмийн эрүүл мэндийн магистрийн зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл

Улаанбаатар хот

2012 он

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ
СУРГУУЛЬ

ДЭМБЭРЭЛИЙН НАНДИН-ЭРДЭНЭ

**ӨРХИЙН ЭМЧ, СУВИЛАГЧДЫН АЖЛЫН БАЙРАН ДАХЬ
НИЙГЭМ-СЭТГЭЛ ЗҮЙН ХҮЧИН ЗҮЙЛ БОЛОН ХАЛШРАХ
ШИНЖ**

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч:

Анагаах ухааны доктор(Ph.D),

М.Сугармаа Эрдэм шинжилгээний ажлын

шүүмжлэгч:

Анагаах ухааны доктор,профессор Г.Сүхбат

Улаанбаатар хот

2012 он

ГАРЧИГ

ТОВЧ ХУРААНГУЙ	
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	5
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	6
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	7
БҮЛЭГ 1. УДИРТГАЛ	
1.1 Судалгааны ажлын үндэслэл	8
1.2 Зорилго	9
1.3 Зорилт	9
1.4 Судалгааны ажлын таамаглал	9
1.5 Шинэлэг тал	10
1.6 Үндсэн ойлголтын тайлбар	10
1.7 Судалгааны ажлын практик ач холбогдол	10
1.8 Хамгаалахаар дэвшүүлж буй асуудлууд	11
1.9 Судалгааны ажлыг хэлэлцүүлсэн байдал	11
1.10 Судалгааны ажлыг хэвлүүлсэн байдал	11
1.11 Судалгааны ажлын ёс зүй	12
1.12 Судалгааны ажлын бүтэц	12
БҮЛЭГ 2. Хэвлэлийн тойм	13
Дэлхий дахинд өрхийн анагаах ухаан үүсч хөгжсөн түүх, орчин үеийн	
2.1 чиг	
Хандлага	13
2.2 Монгол улсын өрхийн анагаах ухааны хөгжил, хууль эрх зүй	14
2.3 Ажлын байрны нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйл,	
түүний онолын үндэслэл	22

2.4 Эрүүл мэндийн өөрийн үнэлгээ	27
2.5 Ажлаас халшрах хам шинж	29
БҮЛЭГ 3. ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГА ЗҮЙ	34
3.1 Судалгааны загвар	34
3.2 Судалгааны хамрах хүрээ, түүвэрлэлт	34
3.3 Мэдээ материал цуглуулсан арга	34
3.4 Чанарын судалгааны мэдээ материал цуглуулсан арга	37
3.5 Статистик шинжилгээ	38
БҮЛЭГ 4. СУДАЛГААНЫ ҮР ДҮН	40
4.1Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагчдын нийгэм сэтгэл зүйн хүчин зүйлс болон халшрах шинжийн түвшинг үнэлсэн үр дүн	40
4.2 Ажил үүргийн талаарх мэдээлэл	42
4.3 Ажлын байран дахь нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйлс Эмч, сувилагч нарын ажлаас халшрах шинж, ажлын байран дахь 4.4 стресст	45
хүргэж буй шалтгаан нөхцлийг судалсан дүн	51
4.5 Эмч, сувилагчдын ажлын байран дахь нийгэм-сэтгэл зүйн сөрөг хүчин зүйлс болон ажлаас халшрах шинжийн хоорондын хамаарал	60
БҮЛЭГ 5. ХЭЛЦЭМЖ	63
ДҮГНЭЛ Т	68
САНАЛ НОМ ЗҮЙ	69
ТАЛАРХАЛ	
ХАВСРАЛТ	

ТОВЧ ХУРААНГУЙ

Өрхийн эмч, сувилагчдын ажлын байран дахь нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйл болон халшрах шинж

Үндэслэл

Монгол улсын хэмжээнд Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг нийт 6778 их эмч, 809 гаруй бага эмч, сувилагч, Улаанбаатар хотод 124, хөдөөд 102 нийт 226 өрхийн эмнэлэгт ажиллаж байна. Өрхийн эрүүл мэндийн төв нэг эмчид дунджаар 1500-1800 хүн ам ноогддог боловч одоогоор нэг эмчид дунджаар 3000 хүн ам ноогддог бөгөөд хүн амынхаа тоогоор эмнэлгийн санхүүжилт нь хийгддэг учир ачаалал ихтэй ажилладаг. Мөн II, III шатлалын эмнэлгийн эмч, сувилагч нарын дунд ажлын байран дахь нийгэм сэтгэл-зүйн хүчин зүйлс, халшрах шинжийн талаарх судалгаа хийгдсэн боловч өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нарын дунд хийгдээгүй байгаа тул энэхүү судалгааг сонгож хийх үндэслэл болж байна.

Зорилго

Өрхийн эрүүл мэндийн төвд ажиллаж буй эмч, сувилагч нарын ажлын байран дахь нийгэм сэтгэл зүйл болон ажлаас халшрах шинжийг тодорхойлж, тэдгээрийн хоорондын хамаарлыг судлах

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй

Судалгаанд нийслэлийн 4 дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 250 эмч, сувилагч нарыг хамруулсан.

Ажлын байран дахь нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйлсийг Хөдөлмөр-урамшууллын загвар (Effort- Reward Imbalance model, Siegrist, 1996)-аар халшрах шинжийг Копенгагений халшрах шинжийн асуумж (Copenhagen Burnout Inventory, Kristensen, 2004)-аар тус тус үнэлсэн. Мөн чанарын арга ашиглан 15 асуулт бүхий ганцаарчилсан ярилцлагаар өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нарын ажлын байран дахь стресст хүргэж буй шалтгаан нөхцлийг тус тус илрүүлсэн.

Үр дүн

Судалгаанд оролцсон өрхийн эрүүл мэндийн төвийн эмч сувилагчдын дундаж нас 37.04(± 10.2). Эмч, сувилагч нарын ажлын байран дахь нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйл болох хөдөлмөр зүтгэлийн дундаж оноо 12.4(± 3.7), урамшууллын оноо 46.5 (± 5.9), хөдөлмөр урамшууллын харьцаа 0.61 (±0.27) байна. Энэ нь эмч нарт ажлын стресст хүргэх нийгэм сэтгэл зүйн таагүй хүчин зүйлсийн тархалт өндөр байгаа нь статистик магадлал бүхий ялгаатай байв. Мөн ажлын байрны нөхцлийн үр дагавар болох халшрах шинжийн тархалтыг авч үзвэл судалгаанд оролцсон эмч, сувилагч нарын хувь хүний халшрах шинжийн дундаж оноо 44.47 (±0.27), ажлаас халшрах шинжийн дундаж оноо 43.90 (±14.85), үйлчлүүлэгчээс халшрах шинжийн дундаж оноо 31.89 (±17.87) байна. Энэ нь халшрах шинжийн дундаж оноо нь эмч, сувилагч нарын хувьд статистик магадлал бүхий ялгаагүй байв. Мөн чанарын судалгааны үр дүнгээр өрхийн эрүүл мэндийн төвд ажилладаг эмч, сувилагч нарын ажлын байран дээрээ хамгийн их бухимддаг хүчин зүйлс нь ажлын ачаалал их, үйлчлүүлэгчийн харилцаа хандлага муу, ажлын үнэлгээ муу зэргээс болж ажлын байран дээрээ бухимддаг байна.

Дүгнэлт

Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нар нь ажлын байран дахь нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйлсийн үзүүлэлтээр авч үзэхэд хөдөлмөр зүтгэл их, урамшуулал багатай хөдөлмөрийн орчинд ажиллаж байна. Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нарын ажлын ачаалал их нэг эмчид ноогдох хүн амын тоо их боловч тохирсон санхүүжилт, цалин, урамшуулал хангалтгүй байна. Өрхийн эмнэлгийн эмч сувилагч нарын ажлын байран дахь нийгэм сэтгэл зүйн хүчин зүйлс болох хөдөлмөр урамшууллын тэнцвэргүй байдал нь ажлаас халшрах шинжтэй шууд хамааралтай байна.

Түлхүүр үг нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйл, халшрах шинж, өрхийн эрүүл мэндийн төв

Abstract

A study on psychosocial factors at work and burn-out among physicians and nurses in primary health care center

Background

There are 6778 physicians, over 809 physician's assistants, nurses who work in primary health care in Mongolia. 124 clinics are located in Ulaanbaatar city among 226. One physician should be in charge of 1500-1800 people, but since the family group practice finance is based on the number of population, the number has reached to 3000 person per physician, resulting in overload of patients. The fact that health profession itself has higher risk of job related stress and burnout, and their working condition, work overload can lead to low productivity has not been studied before, thus rationalizing the cause of this study.

Aim

To assess psychosocial factors at work and burnout among physicians and nurses of primary health care centers and determine its association

Subjects and methods

250 physicians and nurses from 4 district hospitals participated in the study.

Psychosocial factors at work were measured by Effort-Reward imbalance model (Siegrist, 1996). Burnout was assessed by Copenhagen Burnout Inventory (Kristensen, 2004). In depth interview was used to determine the main factors of job stress and burnout.

Results

The means age of the physicians and nurses was 37.04($\pm$ 10.2), effort-commitment mean score 12.4($\pm$ 3.7) as one of the main psychosocial factor, reward mean score 46.5 ($\pm$ 5.9), effort-reward ratio was 0.61 ($\pm$ 0.27) showing that unfavorable psychosocial factors are high. Personal burnout mean score 44.47 ($\pm$ 0.27) of all the subjects showed, mean score 43.90 ($\pm$ 14.85) work related burnout, 31.89 ($\pm$ 17.87) caused from the client related burnout. The mean score for burnout was not differ between the two groups (nurses and physicians). Seeing from quality study results, it is clear that work load, lack

of adequate communication and evaluation are the most important factors to cause stress among physicians, nurses working at primary care. The mean score of effort was high and reward was low among physicians. Burnout score was increased by 108.93-153.16 points per 1 unit increase in effort reward ratio. Compared to level of psychosocial work stress factors and burnout among doctors and nurses, nurses had a higher risk of personal burnout.

Conclusion

Being one of the psychosocial factors, the effort mean score is higher in physician group than in nurse group and reward is low. Negative psychosocial factors were more affecting the physician group. Even if the number of people per physician is high, and overloaded the health professionals have not enough salary. Effort reward imbalance at work is positively associated with burnout symptoms among physicians and nurses of primary health centers in Ulaanbaatar.

Key words: psychosocial factors, burnout, primary health care centers/or family group practice